

42

БАТЛАВ:

2014 оны 05 сарын 30 -ны өдөр

"БИДИСЕК" ХК

Б.ЛХАГВАДОРЖ
ТУЗ-ИЙН ДАРГА

"БиДиСЕК"- ИЙН ТЕЛ-И ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмаар "БиДиСек" ХК-ийн нэмэлт нөхцөлтэй Тел-И үйлчилгээ буюу утсаар захиалга өгөх болон цахим арилжаанд оролцох үйлчилгээтэй холбогдон гарах харилцагч, компанийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журамд хэрэглэгдэх нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1 Харилцагч гэж Тел-И үйлчилгээг авах эрх бүхий "БиДиСек" ХК-ийн харилцагч

1.2.2 "Тел-И" үйлчилгээ гэдэг нь:

- Баталгаат утас, цахим арилжаагаар үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгөх
- Цахим арилжааны программд нэвтрэн өөрийн мэдээллээ авах
- Дансны хуулгаа арилжаанд орсон тухай бүрт нь цахим арилжааны программаас авах
- Клиринг банкны дансны хуулгыг өөрийн хүсэлтээр цахим шуудангаар хүлээн авах

1.2.3 Цахим арилжаа гэдэг нь харилцагч интернэт ашиглан үнэт цаасны захиалга өгөх, дансны мэдээллээ хянах бололцоог хангасан "БиДиСЕК" ХК-ийн Тел-И үйлчилгээний "online trade" программыг хэлнэ.

1.2.4 Цахим арилжаанд нэвтрэх, нэр, нууц үг нь харилцагчийг таних, харилцагчийн мэдээллийн нууцлалыг хангах зорилгоор хэрэглэгдэх тоон болон үсгэн илэрхийлэл байна.

1.2.5 Захиалга баталгаажуулах түлхүүр үг гэдэг нь харилцагчийн захиалгын аюулгүй байдал, нууцлалыг хангах зорилгоор хэрэглэгдэж буй тусгай код байна. Уг түлхүүр үг нь харилцагч өөрөө нууцлах шаардлагатай нууц мэдээлэлд хамаарна.

1.2.6 Тел-И үйлчилгээний түлхүүр үг гэдэг нь харилцагчийн захиалгын аюулгүй байдал, нууцлалыг хангах зорилгоор хэрэглэгдэж буй “Дансны дугаар_Нэр_Нууц үг” гэсэн үгсийн бүрдүүлбэр байна. Түлхүүр үг нь утас ашиглан захиалга өгөхөд хэрэглэгдэх ба харилцагчийн нууц мэдээлэлд хамаарна.

1.2.7 Баталгаат утасны дугаар гэдэг нь “Тел-И” үйлчилгээг авах эрхтэй харилцагч “БиДиСЕК” ХК дээр өөрийн биеэр ирэлгүй үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгөх дансны хуулгаа шүүлгэх, бусад мэдээлэл авах тохиолдолд хэрэглэх утасны дугаар байна.

1.2.8 Баталгаат цахим шуудангийн хаяг гэдэг нь “Тел-И” үйлчилгээг авах эрхтэй харилцагч брокерийн компани дээр өөрийн биеэр ирэлгүй үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгөх, дансны хуулгаа авах, өөр бусад мэдээлэл авах тохиолдолд хэрэглэгдэх цахим шуудангийн хаяг байна.

1.2.9 Баталгаат гарын үсэг гэдэг нь “Харилцагчаа таних маягт”-ын дагуу үйлдсэн гарын үсгийн хэв байна.

1.2.10 Баталгаат банкны дансны дугаар гэж үнэт цаас худалдсан болон ногдол ашиг хүлээн авах харилцагчийн харилцдаг банкны өөрийн нэрийн болон хамтран эзэмшдэг банкны дансны дугаар байна. Харилцагчийн “ҮЦК” -д бүртгүүлэх банкин дах дансны дугаар хэд хэд байж болно.

1.2.11 Үйлчилгээний хураамж гэж “ҮЦК”-иас нэмэлт үйлчилгээ авч байгаа төлбөрийг хэлнэ.

1.2.12 Бүртгэлийн программ гэж Тел-И үйлчилгээг хэрэглэдэг, харилцагчийн мэдээллийг цахим хэлбэрээр хадгалсан тусгай бүртгэлийн систем байна.

ХОЁР. “Тел-И” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЧИМ

2.1 “БиДиСек” ХК-ийн харилцагчийн эрх ашгийг хамгаалах, харилцагчийн нууцлалыг хангаж ажиллах үүднээс дараах зарчмыг баримталж ажиллана.

2.1.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, “БиДиСек” ХК-ийн үйл ажиллагааны дотоод журам, эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох журмуудыг мөрдлөг болгон ажиллана.

2.1.2 Уг үйлчилгээг үзүүлэх брокер нь Санхүүгийн Зохицуулах Хорооны /цаашид Хороо гэх/ сургалтанд хамрагдаж эрх авсан байна.

2.1.3 Тел-И үйлчилгээний нөхцөл хангаж буй харилцагчдад тэгш эрхтэйгээр тус үйлчилгээг үзүүлэх.

44

2.1.4 Уг үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай хүний болон техникийн нөөц бололцоотой байх.

2.1.5 “Тел-И” үйлчилгээг харилцагчтай нэмэлт нөхцлөөр байгуулсан гэрээний дагуу үзүүлэх.

ГУРАВ. ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Тел-И үйлчилгээ үзүүлж байгаа брокерт дараах үйл ажиллагааг хориглоно.

3.1.1 Харилцагчийн түлхүүр үг болон бусад нууцлалаар баталгаажаагүй захиалгыг хүлээн авах,

3.1.2 Харилцагчийн өгсөн захиалгыг дур мэдэн өөрчлөх,

3.1.3 Тус үйлчилгээний гэрээнд заасан хязгаарлалтаас хэтэрсэн захиалга авах,

3.1.4 Брокер харилцагчийн нууц мэдээллийг бусдад задруулах ,

3.1.5 Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журамд заасан бусад хориглох заалт,

ДӨРӨВ. “Тел-И” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

4.1 “Тел-И” үйлчилгээг сүүлийн хагас жилд 5 сая төгрөгнөөс доошгүй үнийн дүнтэй арилжаа хийсэн, эсвэл дансандаа 20 саяас дээш төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны үлдэгдэлтэй “БиДиСек” ХК-ийн харилцагч авах эрхтэй.

4.2 “Тел-И” үйлчилгээний жилийн хураамж 40,000 төгрөг байна.

4.3. “БиДиСек” ХК нь зах зээл дээр үнэт цаасны зохиомол эрэлт нийлүүлэлт үүсгэх, ханшын зохиомол хэлбэлзэл бий болгох зэргээс сэргийлэх зорилгоор “Тел-И” үйлчилгээнд дараах хязгаарлалтыг хэрэглэнэ. Үүнд:

- Харилцагч нь “Тел-И” үйлчилгээний утсаар дамжуулан арилжаанд ороход нэг удаагийн захиалгын нийт үнийн дүн 5,000,000 /таван сая/ төгрөг хүртэл байна.

4.4 Харилцагчийн үйл ажиллагааны онцлог, арилжааны үнийн дүн зэргээс хамаарч харилцагчтай тохиролцсоны үндсэн дээр компанийн менежерийн шийдвэрээр энэхүү журмын

4.1 болон 4.3-т заасан нөхцлүүдийг гэрээгээр өөрчлөн тогтоож болно.

ТАВ. “Тел-И” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

5.1 “БиДиСЕК” ХК нь харилцагчтай цахим арилжаа болон утсаар захиалга өгөх үйлчилгээ үзүүлэхдээ “Тел-И” үйлчилгээний гэрээ байгуулна.

205

5.2 Тус гэрээг байгуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.3-д заасны дагуу “Харилцагчаа таних маяг”-ыг /Хавсралт1, хавсралт2/-ыг ашиглана.

5.3 Тел-и үйлчилгээний гэрээнд дараах зүйлсийг тусгахыг хориглоно. Үүнд:

- 5.3.1 ҮЦК хууль бус үйл ажиллагааны улмаас харилцагчид хохирол учруулснаас үүсэх хариуцлагын хязгаарлалт, учирсан хохирлыг барагдуулах төлбөрийн дээд хэмжээг заах;
- 5.3.2 Харилцагчийн хууль тогтоомж болон гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлэх, гэрээг цуцлах эрхийг хязгаарлах, эсхүл аль нэг талд давуу эрх олгох;
- 5.3.3 Иргэний хуулийн 198.1 дэх заалтын дагуу үгийн шууд утгаар харилцагчид ойлгогдох боломжгүй, маргаан гарсан тохиолдолд өөрт ашигтай утгаар тайлбарлах боломжтой заалт;

ЗУРГАА. ХАРИЛЦАГЧТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

6.1 Брокер нь “Тел-И” үйлчилгээний гэрээг энэхүү журмын 4.1 дэх нөхцлийг хангаж буй хувь хүн бол насанд хүрсэн иргэнтэй, хуулийн этгээд бол үнэт цаасны дансыг хууль ёсоор захиран зарцуулагчтай байгуулна.

6.2 Брокер нь дараах бичиг баримтын бүрдүүлбэр болон шалгуурыг хангасан харилцагчтай гэрээ үйлдэж үйлчилгээ авах эрхийг олгоно.

6.2.1 “Тел-И” үйлчилгээний харилцагчаа таних маягт бөглөсөн байх. /Хавсралт1, Хавсралт2/

6.2.2 Сүүлийн хагас жилийн арилжааны үнийн дүн 5 сая төгрөгөөс доошгүй, эсвэл дансны үлдэгдэл 20 сая төгрөгийн дүнтэй болохыг баталсан дансны дэлгэрэнгүй хуулга.

6.2.3 Үйлчилгээний жилийн хураамжийн төлбөр болох 40,000 төгрөгийг төлсөн баримт /Брокерийн компани дээр тушаасан байна/.

6.2.4 Сүүлийн нэг жилийн дотор авахуулсан 3*4 хэмжээтэй цээж зураг.

6.2.5 Иргэний цахим үнэмлэх эсвэл гадаад паспорт хавсаргах /хүчинтэй хугацаа дуусаагүй байх/

6.3 Харилцагч нь “Тел-И” үйлчилгээний Харилцагчаа таних маягтад дараах зүйлсийг үнэн, зөв бөглөсөн байна.

6.3.1 Захиалга өгөх хэлбэр, хуулга авах хэлбэрээ тодорхойлсон байх.

6.3.2 Баталгаат цахим шуудангийн хаяг, Баталгаат утасны дугаар, Харилцдаг банкны баталгаат дансны мэдээлэл тусгах.

2/6

- 6.3.3 Харилцагч баталгаат гарын үсгээ зурсан байх.
- 6.4 Брокер гэрээ болон харилцагчаа таних маягтыг хүлээн авч бүрдүүлбэрийн бүрэн эсэхийг шалган мэдээллийг бүртгэлийн программд оруулна.
- 6.5 Брокер харилцагч руу нууц үг болон уг үйлчилгээний зааврыг ажлын 1 өдрийн дотор цахим шуудангаар илгээнэ.
- 6.6 Харилцагч цахим арилжааны программд нэвтрэх үедээ ҮЦК-иас илгээсэн нууц үгээ өөрчлөх үүрэг хүлээнэ.
- 6.7 Харилцагч энэ журмын 1.2.4-1.2.6-д заасан мэдээллийг бусдад санаатай болон санамсаргүй дамжуулсан, алдсанаас үүдэн гарах аливаа эрсдэлийг ҮЦК хариуцахгүй.

ДОЛОО. ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ, ӨӨРЧЛӨХ, ЦУЦЛАХ, ДУУСГАВАХ БОЛОХ

7.1 Утсаар захиалга хүлээн авах

- 7.1.1 Утсаар захиалга хүлээн авахдаа дуу хоолойны бичлэгээр баталгаажуулна.
- 7.1.2 Дуу хоолойны бичлэгээр баталгаажсан захиалгыг хүчин төгөлдөрт тооцно.
- 7.1.3 Брокер утсаар захиалга авахдаа харилцагчийн дансны дугаар, түлхүүр үгийг лавлах ба шаардлагатай тохиолдолд регистрийн дугаарыг лавлана.
- 7.1.4 Баталгаат утасны дугаарыг бүртгэлийн программтай тулгана.
- 7.1.5 Утсаар өгсөн захиалгад дараах зүйлсийг харилцагчтай заавал тохиролцож тусгасан байна.
 - 7.1.5.1 Үнэт цаас худалдах, худалдан авах аль нь болох,
 - 7.1.5.2 Үнэт цаасны нэр,
 - 7.1.5.3 Тоо ширхэг,
 - 7.1.5.4 Нэгжийн үнэ,
- 7.1.6 Брокер харилцагчийн өгсөн захиалгыг шалгаж үзээд ханшын хязгаар, шимтгэлийн хувь, арилжааны үнийн дүнгийн хязгаар хэтэрсэн эсэхийг шалгана.
- 7.1.7 Захиалга шалгуур хангаж байгаа тохиолдолд компанийн баталсан захиалгын гэрээнд бичгээр бүртгэн түүн дээр гарын үсэг зурах өдрийг харилцагчид сануулна.
- 7.1.8 Брокер харилцагчийн өгсөн захиалгыг дараа өдөрт нь багтаан дилерт шилжүүлснээр уг захиалгыг биелүүлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 7.1.9 Утсаар ярьж дуусаад дуу хоолойны бичлэгийг бичгээр үйлдсэн захиалгын гэрээтэй тулгаж хянана. Үл ойлгогдох зүйл гарсан тохиолдолд харилцагчтай дахин холбогдон баталгаажуулна.
- 7.1.10 Утсаар ярьсан бичлэгийг компьютерт тусдаа фолдер үүсгэн хадгална.

44

7.1.11 Брокер харилцагчаар товлосон хугацаанд гарын үсэг зуруулах ба хугацаандаа зурж байгаа эсэхийг хянана. Хугацаандаа ирээгүй харилцагчид "Тел-И" үйлчилгээг үзүүлэхээс татгалзаж болно.

7.2 Цахим арилжаа

7.2.1 Харилцагч нь цахим арилжаанд орохдоо "Тел-И" үйлчилгээний гэрээ байгуулж, харилцагч зөвхөн өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан цахим арилжааны программд холбогдоно.

7.2.2 Нууц үгийг компанийн дотоод программаас харилцагчийн бүртгүүлсэн баталгаат цахим шуудангийн хаягаар илгээнэ.

7.2.3 Харилцагч энэ журмын 6.6-д заасны дагуу компаниас илгээсэн нууц үгийг өөрчлөх үүрэгтэй.

7.2.4 Цахим арилжааны талаарх ойлголтыг харилцагчтай анх гэрээ байгуулахдаа брокер өгөх бөгөөд мөн харилцагчийн цахим шуудангийн хаягаар илгээнэ.

7.2.5 Цахим арилжааны программ нь харилцагчид дансны үлдэгдэл шалгах, дансны шилжилгээ харах, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны мэдээ харах, гүйлгээний хуулга үүсгэх, хэвлэх, захиалга өгөх, цуцлах, биелэгдсэн захиалгын мэдээлэл хүлээн авах боломжтой байна.

7.2.6 Харилцагч цахим арилжаагаар үнэт цаас худалдах, худалдан авах захиалга өгөхдөө компаниас илгээсэн түлхүүр үгээр баталгаажуулна.

7.2.7 Брокер цахим арилжаагаар илгээсэн харилцагчийн захиалгыг ҮЦК-ийн дотоод захиалгын гэрээний маягтад хэвлэн хадгалах ба ингэхдээ уг гэрээнд харилцагчийн бүртгүүлсэн баталгаат гарын үсгийн хэв, дансны дугаар, овог нэр, регистрийн дугаар, захиалгын мэдээлэл зэргийг тусгасан байна.

7.2.8 Харилцагч цахим арилжааны нэвтрэх нэр, нууц үгээ мартсан тохиолдолд энэ тухай брокерт бичгээр хүсэлт гарган шинэчлэн авах боломжтой.

7.2.9 Брокер энэ журмын 7.2.8-д заасан хүсэлтийг зөвхөн харилцагчаас өөрөөс нь хүлээн авч шинэчилсэн нэр, нууц үгийг журмын 7.2.2-д заасны дагуу илгээнэ.

7.2.10 Харилцагч шинэчилсэн нууц үгээ энэ журмын 6.6-д заасны дагуу өөрчлөнө.

НАЙМ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДОТООД ХЯНАЛТ

- 8.1 Харилцагчийн албаны менежер долоо хоног бүр "Тел-И" үйлчилгээг үзүүлж буй брокерын үйл ажиллагаа, захиалгын бүртгэлд зохих хяналтыг тавина.
- 8.2 Брокер долоо хоног бүр ажлын тайландаа "Тел-И" үйлчилгээний талаар тусгана.
- 8.3 Шаардлагатай гэж үзвэл "Тел-И" үйлчилгээг үзүүлж буй брокерын үйл ажиллагаанд харилцагчийн албаны менежер тодорхой хугацааны турш байнгын хяналт тавьж брокерт заавар зөвлөгөө өгнө.
- 8.4 Компанийн дотоод хяналтын ажилтан нь шаардлагатай гэж үзвэл "Тел-И" үйлчилгээнд хяналт тавьж Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороонд жилд 1 - с доошгүй удаа тайлагнана.

ЕС. БИЧИГ БАРИМТ ХАДГАЛАХ

- 9.1 "Тел-И" үйлчилгээтэй холбогдох бичиг баримтыг компанийн архивт хадгална.
- 9.2 Холбогдох баримт гэдэгт:
 - 9.2.1 "Тел-И" үйлчилгээний гэрээ
 - 9.2.2 Харилцагчаа таних маягт
 - 9.2.3 "Тел-И" үйлчилгээний цахим бүртгэл
 - 9.2.4 Үнэт цаас худалдах, худалдан авах харилцагчийн захиалгатай холбоотой гэрээ, бичиг баримт, дуу хоолойны болон дүрст бичлэг.
 - 9.2.5 Харилцагчийн дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой баримтууд.
 - 9.2.6 Харилцагчийн гаргасан гомдол, түүний агуулга, шийдвэрлэсэн байдал, гэрээ хэлцэл зэрэг бусад баримтууд.

АРАВ. ХАРИУЦЛАГА

- 10.1 Харилцагч болон "БиДиСЕК" ХК-ийн хариуцлагыг үйлчилгээний гэрээгээр зохицуулна.
- 10.2 "БиДиСЕК" ХК, Харилцагч, брокер нь Хорооны "Үнэт цаасны зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам"-д заасан хариуцлагын тогтолцоог баримтална.